

ӨМНӨД СОЛОНГОСЫН ЗОЧИН МОНГОЛЫН ТУХАЙ

БН Солонгос улсын Солонгос судлалын академийн ерөнхийлөгч, профессор Ли Хен-же ШУА-ийн ерөнхийлөгч Д. Баатарын урилгаар манай оронд зочлох хугацаандаа 1992.8.17-нд тус хүрээлэнгийн эрдэмтэдтэй уулзалт хийж Солонгос судлалын Академийг танилцуулахын хамт Монголын цаашдын хөгжлийн талаар санал бодлоо хуваалцсан билээ. Тэрбээр Сеулын үндэсний Их Сургуулийн захирлаар олон жил ажилласнаас гадна Өмнөд Солонгосын ерөнхий сайдын албыг нэгэн үе хашиж байсан ажээ. Эдүгээ Солонгос судлалын Академийг удирдахын зэрэгцээ боловсролын асуудлаархи ерөнхийлөгчийн комиссын дарга, Солонгосын эдийн засгийн нийгэмлэгийн хүндэт ерөнхийлөгч юм байна. Энэхүү эрдэм мэдлэг, дадлага туршлага хоёрыг хослуулан хүндэт зочныхоо санал бодлыг уншигч та бүхэндээ хүргэх нь зүйтэй гэж үзсэн юм.

Сэтгүүлийн редакц

ЗХУ-ын Перестройка явагдсанаас хойш улс түмний харилцаанд шинэ үе эхэллээ. Дэлхийн II дайнаас хойш тогтож байсан Ялтын систем үндсэндээ нурсан гэж хэлж болно.

Солонгос судлалын Академи нь анх 1978 онд байгуулагдсан юм. Нэг үе манай оронд эдийн засгийн судалгааг голлосон тул түүх, соёлын судалгаа хоцрогдсон тал бий. Иймд энэ өрөөсгөл явдлыг засварлаж, солонгосчуудын үндэсний бахархлыг сэргээх үүднээс Академи байгуулсан учиртай.

Танай Монгол улсын нутаг Өмнөд Солонгосын нутгаас 15 дахин, нийт Солонгосын хойгийнхоос 7 дахин их юм байна. Түүнчлэн Монгол байгалийн баялаг ихтэй. Харин Өмнөд Солонгост байгалийн баялгаа барж дууссан гэж хэлэхэд болно. Эдийн засгаа төлөвлөгөөтэй хөгжүүлсэн жишээг манай орноос харж болно. 1962 оноос анхдугаар таван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн бол энэ 1992 оноос VП дугаар таван жилийн төлөвлөгөөнд ороод байна. Өнгөрсөн 1991 онд Өмнөд Солонгосын жилийн импорт 70 тэрбум доллар, жилийн экспорт 65 тэрбум доллар болсон. Миний хувьд 80-аад оны хоёрдугаар хагаст шинэ иргэний засгийн газрын ерөнхий сайдаар ажиллах хувь тохиолдсон. Тэр жилүүд Сеулын олимптой ч яг давхацсан. Тухайлбал, 1988 оны үед Өмнөд Солонгосын гадаад худалдаа 10 тэрбум долларын ашигтай байсныг санахад илүүдэхгүй.

Өмнөд Солонгосын хүн ам танай Монголын хүн амаас 20 дахин их болно. Бидний олж үзсэнээр 1989 онд нэг хүнд ноогдох үндэсний орлого Монголд 552 ам. доллар байжээ. Тэгвэл 1962 онд Өмнөд Солонгост энэ үзүүлэлт 300 ам. доллар хүрэхтэй үгүйтэй байсан. Өөрөөр хэлбэл, хэрвээ энэ тоо баримт бодитой бол танай хөгжлийн гарааны нөхцөл манайхаас давуу байна гэсэн үг.

Монгол улс цаашид эдийн засгаа хөгжүүлэхдээ хамгийн гол салбараа барьж авч. Эхлээд түүнд хүчээ төвлөрүүлэн дараа нь түүгээр дамжуулан бусад салбараа өөд татах маягаар ажиллах нь зүйтэй болов уу. Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагаас зээл авч улс орныхоо дэд бүтцийг хөгжүүлэх нь оновчтой. Танай оронд төлбөрийн хэрэгсэл дутагдаж байгаа нь ойлгомжтой. Материаллаг үйлдвэрлэл явуулахгүй хатуу валют олох арга нь жуулчлал гэдгийг та бүгд мэднэ. Түүнчлэн эхний үед гадаадын хөрөнгө оруулалтаас нэг их болгоомжлох хэрэггүй болов уу. Хэрвээ Монголын үндэсний орлогод ху-

римтлалын фондын эзлэх хувийн жин 10 орчим хувь байдаг бол энэ нь тийм ч доогуур үзүүлэлт биш байна. 1962 онд Өмнөд Солонгост энэ үзүүлэлт дөнгөж 2% байсныг хэлэхэд хангалттай.

Гарааны эхэн үед санхүүгийн системийг зөв бүрэлдүүлэх нь их чухал. Төв банкнаас гадна арилжааны банкууд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Хүн ам, ялангуяа малчид мөнгө авдрандаа хийх, бус банкинд авчирч эргэлтэнд оруулах сонирхлыг төрүүлэх нь засгийн газрын зорилго мөн. Хадгаламжийн хүүг нэмэх зэрэг аргаар зохих механизмыг бүрдүүлж болно.

Мөн нэг зүйлийг нэмж хэлмээр санагдаад байна. Танай оронд амралтын өдөр нэг л олон юм шиг санагдаад байх юм. Манай оронд бол ердөө 10 жилийн өмнөөс л амралтын өдөртэй болсон. 5 жилийн өмнөөс л бид сард 2 бүтэн сайн өдөр амардаг болсон.

Эцэст нь хэлэхэд танай орон ч тэр танай хөрш Орос, Хятад ч тэр эдийн засгийн хөгжлийн шалгалт өгөх шатандаа явж байна гэж хэлж болно. Энэ шалгалтыг хэр амжилттай давж гарах нь хоёр үндсэн хүчин зүйлээс шалтгаална. Нэг нь зах зээлийн нөхцөлд хүн амын сэтгэл зүйн бэлтгэл хэр түргэн хийгдэхтэй холбоотой. Нөгөө нь эхний үед гаднаас зайлшгүй авах эдийн засгийн зээл, буцалтгүй тусламжийг боловсруулж чадах Монгол улсын ходоодны чадвар ямар байхаас ихээхэн шалтгаална.